АГУУЛГА

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА 2
1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ 2
1.2 ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙРШИЛ 2
БҮЛЭГ II. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 5
БҮЛЭГ III. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ 7
БҮЛЭГ IV. ТЭРБУМ МОД ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 11
Зураг №. 9 Модны тарилтын зураг 12
БҮЛЭГ V. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 12
БҮЛЭГ VI. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 12
БҮЛЭГ VII. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 13
БҮЛЭГ VIII. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 17
БҮЛЭГ IX. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ 18
БҮЛЭГ X. ДҮГНЭЛТ 21

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №. 1 Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн солбицол 2
Хүснэгт №. 2 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл 5
Хүснэгт №. 3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт 8
Хүснэгт №. 4 Тэрбум мод хөтөлбөрийн биелэлт 11
Хүснэгт №. 5 Болзошгүй эрсдэлээс хамгаалах төлөвлөгөөний биелэлт 13
Хүснэгт №. 6 Хамгаалах хэрэгслийн зардлын тооцоо 14
Хүснэгт №. 7 Галын хор сарай зардлын тооцоо 16
Хүснэгт №. 8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт 17
Хүснэгт №. 9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө 18
Хүснэгт №. 10 Мониторингийн цэгийн солбицол 20
Хүснэгт №. 11 Ургамлан бичиглэлийн мониторингийн цэгийн бичиглэлийн солбицол 20

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг №. 1 “Зүүн цагаан хошуу” нэртэй талбайн байршлын тойм зураг 3
Зураг №. 2 Төслийн талбайн сансрын зураг 3
Зураг №. 3 Уурхай орчмын харагдах байдал 4
Зураг №. 4 Замын усалгаа болон зам засвар, тэмдэгжүүлэлт 10
Зураг №. 5 Модны тарилтын зураг 12
Зураг №. 6 Төслийн талбайд байршуулсан галын хор сарааны зураг 15
Зураг №. 7 Гал тогооны өрөөн газ мэдрэгч 15
Зураг №. 8 Мониторингийн цэгүүд 19

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


Төслийн нэр:	“Зүүн цагаан хошуу” нэртэй төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“Эрдэнэмайнинг Үйлс” ХХК нь Монгол улсын 9019079090 тоот бүртгэлийн дугаар, 5924766 регистрийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй.
Мэйл хаяг:	erdeneminingуils@gmail.com
Тусгай зөвшөөрлийн дугаар:	MV-009515
Талбайн хэмжээ:	210.84 га
Төсөл хэрэгжүүлэгчийн тусгай зөвшөөрөл:	АМГТХЭГ-ын ГУУКА-аас 2007 оны 02-р сарын 22-ны өдөр Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Зүүн цагаан хошуу” нэртэй газар, ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийг үндэсэлэн MV-009515 тоот 210.84 гектар талбай бүхий ашигт малтмал ашиглах, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг “Анхай Интернэшнл” ХХК-д олгосон байна. “Анхай Интернэшнл” ХХК-ийн Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Зүүн цагаан хошуу” нэртэй MV-09515 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2-т заасны дагуу Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн “Өмчлөх эрх шилжүүлэх тухай” №01 дугаар тогтоол, мөн албаны 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 1/6803 тоот бичгийг тус тус үндэслэн АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 131 дүгээр шийдвэрээр ашигт малтмал ашиглалтын MV-009515 тоот тусгай зөвшөөрлийг “Эрдэнэмайнинг Үйлс” ХХК-д шилжүүлсэн байна.
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, зайсан, Хатантуул хотхон, 35 тоот, Утас:89102202

1.2 ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙРШИЛ

Зүүн цагаан хошууны төмрийн хүдрийн орд нь Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт, Улаанбаатар хотоос баруун урд зүгт 170 км-т, Бага хангай, Мааньт өртөөнөөс баруун хойд зүгт тус тус 70-65 км, Баянжаргалан сумаас хойд зүгт 15 км-т дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн районд байрлана.

Хүснэгт №. 1 Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн солбицол

№	Зүүн уртраг			Хойд өргөрөг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	108	12	49.54	47	17	17.72
2	108	11	51.54	47	17	17.72
3	108	11	51.54	47	18	13.72
4	108	12	49.54	47	18	13.72



Зураг №. 1 “Зүүн цагаан хошуу” нэртэй талбайн байршлын тойм зураг



Зураг №. 2 Төслийн талбайн сансрын зураг



Зураг №. 3 Уурхай орчмын харагдах байдал

БҮЛЭГ II. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг үнэлэхдээ өмнөх шатанд тодорхойлогдсон болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд, түүний үйлчлэлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нутгийн оршин суугчид, түүх, соёлын өвд бий болох сөрөг үр дагавар, түүний эрчим, цар хүрээ, шууд болон шууд бус нөлөөллүүд, болзошгүй нөлөөллийг Монгол улсын хууль тогтоомжид заасан болон олон улсын нийтлэг аргуудыг ашиглан үнэлсэн байна.

Хүснэгт №. 2 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Байгаль орчны асуудал	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
		бага	дунд	их
1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Голын голдирлыг эвдэж,				
Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал				
Ой модыг огтлох, гэмтээх асуудал				
Түүх соёлын дурсгалт газар, археологи-палентлогийн олдвор	x			
Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх	x			
Булаг, шандны усны горимд өөрчлөлт орох ба хатах, ширгэж үгүй болох аюултай эсэх	x			
2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцэх эсэх, түүхий эдийг олдворлох, боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон орчны бохирдлын хяналтад сонгосон төхөөрөмж нь хир зэрэг зохимжтой			x	
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг тэсэлгээ, хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн				x
Эрдсийг боловсруулах технологийн үйл ажиллагааны үед ус, агаар, хөрс бохирдох, хатуу хог хаягдал болон их дуу чимээ гарах		x		
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх	x			
Уурхайн үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх		x		
3. Барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай				
Барилга байгууламж барих үед усны нөөц бохирдох байдал	x			
Барилга байгууламж барих үеийн болон барьсны дараа хөрсний элэгдэл, эвдрэл		x		
Үйлдвэрлэлийн осол аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл		x		
4. Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хэр зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх				x
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх				x
Хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)				x

Эрдэс баялгийг авч ашиглах зэргээс шалтгаалж хөрсөнд ус нэвчих, гүний ус бохирдох, улмаар хөрсний усны горимд эсрэгээр нөлөөлөх	x			
Газар ашиглалтад хохирол учруулах, үйл ажиллагаа явуулах үед газар тэгшлэх, буцааж булах ажлыг хамгийн бага байлгах нь бусад зорилгод ашигтай байж болох, хөрш зэргэлдээх газар ашиглалтад гэмтэл учруулахгүй байх зэрэг асуудал төсөлд тусгагдсан эсэх			x	
Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, зардал тусгагдсан эсэх)		x		
Төслийг хэрэгжүүлэх үеийн инженерийн болон санхүүгийн боломжийн талаарх асуудал				X
5. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгууруул (бодлогын чанартай асуудлууд)				
Төслийг хэрэгжүүлэх явцад байгалийн бусад нөөц баялгийг ашиглах боломжийг ашиглахгүй орхигдуулах	x			
Төслийн техник, технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд олон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал				X
Дүн	**10**	**5**	**2**	**6**

Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлан жагсаах аргаар үнэлсэн үнэлгээгээр

1. Голын голдирлыг өөрчлөх, хүн амыг нүүлгэн шилжүүлэх, ой модыг огтлох гэмтээх зэрэг бусад 10 асуудлаар ямар нэгэн нөлөөлөл үзүүлэхгүй байна.
2. Уурхайн үйл ажиллагааны үед гарах дуу чимээ, үйлдвэрлэлийн осол аваар, хортой нөхцөл үүсэх гэх мэт 5 асуудлаар бага хэмжээгээр нөлөөлөл үзүүлнэ.
3. Дунд зэрэг өртөх 2 асуудлаар нөлөөлөлтэй байна.
4. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг тэсэлгээ, хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал, төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хэр зэрэг бодитой шаардлага хангасан зэрэг 6 асуудлаар төслөөс их нөлөөлөлтэй байна.

Эдгээр асуудлуудад анхаарал хандуулах тодорхой үе шатанд зохих урьдчилан сэргийлэх ажлуудыг авч байх нь зүйтэй.

БҮЛЭГ III. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

"Эрдэнэмайнинг Үйлс" ХХК-ийн 2026 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь уг төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулах бүхий л үе шатыг хамрах ба гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах арга хэмжээ буюу төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, 2014 оны А-117 тоот тушаалын 4-р хавсралтаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг тус тус баримтлан боловсруулж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудсыг хөтөлбөрт хавсаргасан бөгөөд БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ажил хийгдэхгүй болно.

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд **13,126,000** төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримтлах арга зүй, стандарт, холбогдох эрх зүйн баримт бичгийн заалт, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилт:

1. Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг үнэлэх /Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланд тусгагдсан болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд (БОМТ) тусгасан арга хэмжээнүүд хэрхэн хэрэгжсэн тухай мэдээлэх/

2. Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг хянах, бууруулах явцыг тайлагнах /Төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг хэрхэн хянаж, бууруулж байгааг харуулах/

3. Хяналт, мониторингийн үр дүнг тайлагнах /Агаар, ус, хөрс, дуу чимээ, биологийн олон янз байдал гэх мэт байгаль орчны үзүүлэлтүүдийг хэмжсэн дүн болон тэдгээрт хийсэн шинжилгээний үр дүнг тусгах/

4. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр авсан арга хэмжээ, үр дүнг харуулах /Хог хаягдлын менежмент, нөхөн сэргээлт, мод тарилт, эрчим хүчний хэмнэлт гэх мэт бодит ажил, үр дүнг тайлагнах

5. Хууль, эрх зүйн шаардлагуудын биелэлтийг нотлох /Байгаль орчны холбогдолтой хууль, дүрэм, стандартуудын шаардлагыг хангаж байгаа эсэхийг харуулах.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт №. 3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	2025 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт
	1	2	3	4	5	6	7	
1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
1	Агаарын чанар	Тоосжилтыг бууруулах замаар уурхай орчмын технологийн замыг хуваарийн дагуу усалж, тэгшлэн засаж сайжруулж арчилж байх	Уурхайн бүсэд	Тухай бүр	Хуваарийн дагуу	Дотоод зардал	Дотоод зардал	Тоосжилтыг бууруулах замаар уурхай орчмын технологийн замыг хуваарийн дагуу усалж, тэгшлэн засаж сайжруулж арчилсан Уурхайн олборлолт, хөрсний овоолго үүсгэх, шороон замаар тээвэрлэлт хийх үед усалгааг тоосжилтыг бууруулах зорилгоор хур тунадас ороогүй үед хяналтын бүсэд тоосжилт үүссэн үед шүүрлийн ус болон саарал усыг зориулалтын шүршигчээр шүршиж заншсан.
2		Уурхайн техник, хэрэгслийн үзлэг оношилгоонд хамруулах	Уурхайн техник хэрэгсэл	Жилд	1 удаа	1,500,000	1,500,000	Уурхайн техник, хэрэгслийн үзлэг оношилгоонд хамруулсан
4		Тээвэрлэлтийн үед хурдны хязгаар тогтоох (40 км/цагаас хэтрэхгүй байх), тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, цаашид засаж сайжруулах	Уурхайн бүсэд	ш	1	200,000	200,000	Уурхайн шороон зам дагуу MNS 4597:2014 стандартын тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.

4	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Усны эх үүсвэрүүдийг тоолууржуулах	Гүний худаг	Сар бүр	1	Дотоод зардал	Дотоод зардал	Өөрийн эзэмшлийн 2 гүний худаг дээр тоолууржуулалт тавьсан	
5		Ус ашиглалтын дүгнэлт гаргуулан, ус ашиглуулах гэрээг холбогдох байгууллагатай хийх	Уурхайн бүсэд	-	Тухай бүр	1,000,000	1,000,000	Ус ашиглалтын дүгнэлт гаргуулан, Хэрлэн голын сав газартай гэрээг байгуулсан	
7		Гүний худгийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах, орчмын цэвэрлэгээ хийх	Төслийн талбайд	Жилд	2 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	Гүний худгийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөж ажилласан, ойр орчмын цэвэрлэгээ хийсэн.	
8	Хөрсөн бүрхэвч	Олборлолт нэмэгдэх бүрд шимт хөрсийг хуулж, тусгай талбайд стандартын дагуу байршуулж, хэлбэржүүлж хамгаалах	Төслийн талбайд	Жилд	1 удаа	Дотоод зардал		Олборлолт нэмэгдэх бүрд шимт хөрсийг хуулж, тусгай талбайд стандартын дагуу байршуулж, хэлбэржүүлж хамгаалсан.	
9		Асгарсан тос масло хөрс бохирдуулагч аливаа бодис асгарсан тохиолдолд гүнд нэвчихээс сэргийлэх арга хэмжээ авах, саармагжуулах талбайг гаргах	Засварын хэсэг	-	Тухай бүр	Дотоод зардал			
10		Уурхайгаас УБ хот хүрэх гол замын сүлжээ, маршрутыг тогтоох, сайжруулсан зам болгох, цаашид арчилж тордох	Уурхайн нийт талбайд	-	Хуваарийн дагуу	Дотоод зардал	Дотоод зардал	Уурхайгаас УБ хот хүрэх гол замын сүлжээ, маршрутыг тогтоож, сайжруулсан зам болгож байнга арчилж тордож байна.	
Нийт							**2,700,000**		







Зураг №. 4 Замын усалгаа болон зам засвар, тэмдэгжүүлэлт

БҮЛЭГ IV. ТЭРБУМ МОД ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны 07 сарын 09-ны өдрийн А/172, 116 дугаарт “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын нормативыг шинээр болон шинэчлэн батлах тухай” хөтөлбөрийн хүрээнд 1000 ш 3-5 настай улиас, 1000 ш 3 настай бургас мод, 500 ш чацарганыг Багануур дүүргийн мод үржүүлгийн газраас худалдан авч тарьж ургуулан тогтмол нормын усалгаа хийн арчилж хамгаалж байна.

Хүснэгт №. 4 Тэрбум мод хөтөлбөрийн биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	2025 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт
Тэрбум мод хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт								
1	Тэрбум мод үндэсний хөтөлбөр	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд уурхайн кемп орчмоор мод тарих /Орон нутгийн тарьц, суулгацаар /	Уурхайн бүсэд	ш	2000	4,000,000	4,000,000	Тэрбум модны үндэсний хөтөлбөрийн хүрээнд таригдсан модонд нөхөн тарилт хийж арчилж хамгаалж байна. 1000 ш 3-5 настай улиас, 1000 ш 3 настай бургас мод, 500 ш чацарганыг Багануур дүүргийн мод үржүүлгийн газраас худалдан авч тарьж ургуулан тогтмол нормын усалгаа хийн арчилж хамгаалж байна.
2		Тэрбум модны үндэсний хөтөлбөрийн хүрээнд таригдсан модонд нөхөн тарилт хийх	Уурхайн талбайд	ш	500	1,000,000	1,000,000	
Нийт							**5,000,000**	




Зураг №. 5 Модны тарилтын зураг

БҮЛЭГ V. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тухайн төслийн эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

БҮЛЭГ VI. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагааны үед газар дээр ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоон энэ тухай орон нутгийн Засаг дарга, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Иймд түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний ажлыг төлөвлөгөөгүй болно.

БҮЛЭГ VII. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг тусгалаа.

Хүснэгт №. 5 Болзошгүй эрсдэлээс хамгаалах төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	2025 онд хэрэгжүүлсэн Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний биелэлт
1	Болзошгүй гэнэтийн аюул осол, байгалийн давагдашгүй хүчин зүйл Хүний эрүүл мэнд, байгаль орчинд	Галын болон байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Уурхайн нийт талбайд	Жилд	1 удаа	500,000	500,000	Галын болон байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулж шинээр галын сарай, галын хор байршуулсан
2	Газар хөдлөлт, онцгой байдал	Цугларах талбайг тэмдэгжүүлж, заагчлал хийх	Уурхайн талбайд	жил		-	-	Цугларах талбайг тэмдэгжүүлж, заагчлал хийх
3	Эрүүл мэндийн эрсдэл (тоосжилт, утаа, химийн бодис)	Ажилчдыг иж бүрэн хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах (малгай, нүдний шил, амны хаалт, гутал гэх мэт)	Уурхайн талбайд					Ажилчдыг иж бүрэн хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангасан тус бүр 40 ш
4	Гал түймэр	Гал унтраах багаж хэрэгслийн байршлыг тодорхой болгож тоноглох	Уурхайн талбайд				1,565,000	Гал унтраах багаж хэрэгслийн байршлыг тодорхой болгож тоноглосон Гал тогооны өрөөнд газ мэдрэгч суурилуулсан
Нийт							**2,065,000**	

ХАБЭА-ын дүрэм, журмын, ажлын иж бүрэн хувцасны хангалт

Ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор ХАБЭА-ын дүрэм журмын дагуу шаардлагатай бүх төрлийн хамгаалах хэрэгсэл—аюулгүйн малгай, ажлын гутал, тусгай хувцас, амны хаалт, нүдний шил болон бусад хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж ажилласан. Хамгаалах хэрэгслийн хэрэглээг өдөр тутмын шалгалтаар нягталж, ашиглалтын бүртгэл хөтлөн, ажилтнуудыг зохих хамгаалах хэрэгслийг зааврын дагуу тогтмол хэрэглэх талаар сургалт, зааварчилгааг давтамжтайгаар өгсөн. Ингэснээр үйлдвэрлэлийн эрсдэлээс хамгаалсан, аюулгүй ажиллагааны соёлыг төлөвшүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Хүснэгт №. 6 Хамгаалах хэрэгслийн зардлын тооцоо

№	Хамгаалах хэрэгслийн нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ (төг)	Нийт үнэ (төг)	Тайлбар
1	Ажлын хантааз (тусгалтай)	40 ширхэг	60,000	**2,400,000**	Зам талбай, үйлдвэрийн бүсийн ажилтнуудад
2	Ажлын хүрэм, өмд (өргөн хамгаалалттай, дулаан)	40 иж бүрдэл	150,000	**6,000,000**	Өвлийн болон гадаа нөхцөлд ажиллах зориулалттай
3	Аюулгүйн каск	40 ширхэг	35,000	**1,400,000**	Толгойг механик гэмтлээс хамгаалах
4	Хөдөлмөр хамгаллын гутал (ус, дулаан тусгаарлагчтай)	40 хос	120,000	**4,800,000**	Гулгамтгай гадаргуу, хүйтэнд тэсвэртэй
5	Хамгаалалтын нүдний шил	40 ширхэг	15,000	**600,000**	Тоос, химийн уур, хаягдлаас хамгаалах
6	Амьсгалын баг (N95 стандарт)	40 ширхэг	12,000	**480,000**	Тоосжилт, хий, уураас хамгаалах
7	Хөдөлмөр хамгаллын бээлий	40 хос	8,000	**320,000**	Механик гэмтэл, халуун, химийн бодисоос хамгаална
8	Холбооны хэрэгсэл (гар станц)	5 ширхэг	250,000	**1,250,000**	Ажилчдын хооронд шуурхай холбоо тогтоох

1. Галын хор сарай

Төслийн талбайд галын аюулгүй байдлыг хангах зорилгоор стандартын шаардлага хангасан галын хор, гал унтраах хэрэгслийг зохих байршлуудад суурилуулан байршуулсан. Галын хор байрлуулах байршлыг тодорхой тэмдэглэгээ, заагч тэмдэгтэйгээр тэмдэглэж, ажилчдын хүртээмжтэй байхаар төлөвлөн байрлуулсан.

Мөн галын хорын бүрэн бүтэн байдал, хүчинтэй хугацаанд хяналт тавьж, улирал бүрийн үзлэг, техник үйлчилгээний бүртгэлийг хөтөлж ажилласан. Энэ нь галын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ажилчдын аюулгүй ажиллагааг хангах чухал нөхцөл болж байна.





Зураг №. 6 Төслийн талбайд байршуулсан галын хор сарааны зураг





Зураг №. 7 Гал тогооны өрөөн газ мэдрэгч

Хүснэгт №. 7 Галын хор сарай зардлын тооцоо

№	Орц, материал, тоног төхөөрөмж	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ (₮)	Нийт үнэ (₮)	Тайлбар
1	Металл сарай (төмөр тор, хүрээ, гагнаас, будаг)	иж бүрдэл	1	850,000	850,000	1.5×1.5×1.8 м хэмжээтэй, төмөр хийцтэй
2	Галын хор – ABC төрөл (6 кг)	ширхэг	2	95,000	190,000	Хөөс, нунтаг холимог, олон төрлийн галд
3	Галын хор – CO_2 төрөл (5 кг)	ширхэг	1	120,000	120,000	Цахилгаан тоног төхөөрөмжийн галд
4	Элс хадгалах төмөр хайрцаг	ширхэг	1	150,000	150,000	0.3 м³ багтаамжтай
5	Галын хүрз	ширхэг	1	25,000	25,000	Төмөр, иштэй
6	Галын хувин	ширхэг	1	15,000	15,000	Металл
7	Элс (хуурай, угаасан)	кг	50	300	15,000	Хайрцагт хийж хадгална
8	Анхааруулах тэмдэг, пайз	иж бүрдэл	1	20,000	20,000	“Fire Point” / “Галын хор байрлах цэг” гэх мэт
9	Суурилуулалт, гагнуур, будаг, тээвэр	ажил	1	180,000	180,000	Хөдөлмөрийн хөлс, шатахуун, материал багтсан

Нийт зардал: 1,565,000 ₮ (Нэг сая таван зуун жаран таван мянган төгрөг) (НӨАТ ороогүй дүн)

2. Тээврийн хэрэгжлийн үзлэг, тэмдэглэл, хяналтын ажиллагаа

Үйлдвэрийн бүхий л тээврийн хэрэгсэлд өдөр бүр урьдчилсан үзлэг хийх журмыг мөрдлөг болгон хэрэгжүүлж байна. Жолооч нар хөдөлгөөнд гарахаас өмнө дараах үзлэгийг хийж, тусгай бүртгэлийн дэвтэрт тэмдэглэн баталгаажуулдаг. Үүнд:

- Хөдөлгүүрийн тос, хөргөлтийн шингэн, гидрийн тосны түвшин
- Дугуйн даралт, элэгдэл
- Тоормосны ажиллагаа
- Гэрэл, дохиолол, толь
- Аюулгүйн хэрэгсэл (нэмэлт дугуй, галын хор, гурвалжин тэмдэг)
- GPS болон хурд хянах төхөөрөмжийн ажиллагаа

Өдөр бүрийн үзлэгийн тэмдэглэл нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх, тээврийн хэрэгслийн ашиглалтын найдвартай байдлыг дээшлүүлэхэд чухал нөлөөтэй бөгөөд сар бүрийн техникийн хяналтын тайланд нэгтгэн танилцуулж байна.

БҮЛЭГ VIII. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Монгол улсын хууль болон стандартуудыг баримтална. Төслөөс энэхүү үүргүүдээ биелүүлэхдээ эцсийн байдлаар үүсэх хог хаягдлын хэмжээг бууруулах үүднээс хийсэн менежментийн сонголтыг үнэлж дүгнэх арга барилыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт №. 8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт


№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	2025 онд хийж хэрэгжүүлсэн биелэлт
7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөиий биелэлт								
1	Ахуйн	Хог хаягдлыг түр цэгт хадгалах, ангилан ялгаж байршуулах, хог хаягдлыг сумын нэгдсэн цэгт тээвэрлэх, баталгаажуулах	Уурхайн нийт талбайд	-	Тухай бүрт	1,200,000	1,200,000	Түр цэгийг ажлын байрнаас 300 метрт гадаад талбайд байршуулсан, сумын нэгдсэн цэгт тээвэрлэж хаядаг.
2	*Аюултай*	Тос, тослох материалын сав, арчсан материал хэрэгслийг аюултай хог хадгалах байранд түр хуримтлуулах	Төслийн хүрээнд	*Жилд*	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	Тос, тослох материалын сав, арчсан материал хэрэгслийг аюултай хог хадгалах байранд түр хуримтлуулдаг
3		Ажилчдад аюултай хог хаягдлын талаар сэдэвчилсэн сургалт орох	Уурхайн талбайд	*Жилд*	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	Ажилчдад аюултай хог хаягдлын талаар сэдэвчилсэн сургалт оруулсан
4		Аюултай хог хаягдлыг ангилан бүртгэлжүүлж, хэмжээг гаргах	Уурхайн талбайд	*Жилд*	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	-
Нийт							**1,200,000**	

БҮЛЭГ IX. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Эрдэнэмайнинг Үйлс” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

Хүснэгт №. 9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	2025 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт
8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр								
1	Ус	Усны хими,микробиологи, хүнд металлын шинжилгээг өгөх	Гүний худагт	жилд	2 удаа	383,000	766,000	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн мониторингийн цэг тогтоож, лабораторийн шинжилгээг жил бүр Green lab итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн дээжийн хариуг хавсаргав.
2		Унд ахуйн усны шинжилгээг өгөх	Гал тогоо	жилд	2 удаа	200,000	400,000	
3	Хөрс	Хөрсний шинжилгээ /Хөрсний чанар хими физикийн ерөнхий үзүүлэлт, хүнд металл/	Хяналтын 4 цэгт	жилд	2 удаа	310,000	620,000	
4	Агаарын найрлага	Агаарын чанарын хяналт шинжилгээ /тоос,дуу шуугиан, найрлага,доргио чичиргээ/	Агаарын дээж авах 3 цэгт	жилд	1 удаа	300,000	300,000	
								2,086,000



Зураг №. 8 Мониторингийн цэгүүд

Хүснэгт №. 10 Мониторингийн цэгийн солбицол

№	Солбицол	
	Уртраг	Өргөрөг
Усны мониторингийн цэг		
1	$108^0$12’34.0”	$47^0$17’54.7”
2	$108^0$12’35”	$47^0$17’45”
Хөрсний мониторингийн цэг		
1	603533.82	5411591.05
2	603592.39	5411625.7
3	603603.24	5411573.62
Агаарын мониторингийн цэг		
1	5242075.50	288760.42
2	5241998.45	288409.35
3	5241613.23	288839.44
Ургамлын мониторингийн цэг		
1	$108^0$12’37.9”	$47^0$18’04.44”
2	$108^0$12’37.96”	$47^0$17’56.15”
3	$108^0$12’35.96”	$47^0$17’52.11”
4	$108^0$12’39.96”	$47^0$17’49.68”

Хүснэгт №. 11 Ургамлан бичиглэлийн мониторингийн цэгийн бичиглэлийн солбицол

M-ID	Longitude	Latitude	h	Мониторингийн цэгийн нэр
1	$108^0$12’37.9’’	$47^0$18’04.44’’	1480	Хялгана-алаг өвст уулын хээр
2	$108^0$12’37.96’’	$47^0$17’56.15’’	1468	Хялгана-хиаг-шарилжит хээрийн бүлгэмдэл
3	$108^0$12’35.96’’	$47^0$17’52.11’’	1460	Дэрс-хялганат
4	$108^0$12’39.96’’	$47^0$17’49.68’’	1450	Арзгар азаргана ургасан хог овоолсон газар
5	$108^0$12’25.63’’	$47^0$17’47.83’’	1466	2 адилтай адил
7	$108^0$12’24.3’’	$47^0$17’54.79’’	1456	Ажилчдын байр
8	$108^0$12’44.96’’	$47^0$17’37.96’’	1458	Хашааны хаалга, хамгаалалт

БҮЛЭГ Х. ДҮГНЭЛТ

Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт байрлах “Эрдэнэмайнинг үйлс” ХХК-ийн “Зүүн цагаан хошуу нэртэй” төмрийн хүдрийн орд төслийн 2025 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн үр дүнд бид дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- 2025 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 1 дүгээр хавсралтад заасан аргачлалын дагуу боловсруулав;
- 2025 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд нийт **13,051,000** төгрөг зарцуулсан байна. Үүнд
    - Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд нийт зардлыг үйл ажиллагааны мөнгөн дүнд тусгасан байна;
    - Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтэд нийд **2,086,000** төгрөг зарцуулсан байна;
    - Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлтэд **2,065,000** төгрөг зарцуулсан байна;
    - Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтэд **1,200,000** төгрөг зарцуулсан байна;
    - Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтэд нийт **2,086,000** төгрөг;

Тухайн жилийн байгаль орчны менежментийн 5834287125төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтэд нийт зардлыг үйл ажиллагааны мөнгөн дүнд тусгасан байна;